

СОЛОНГОС ҮГИЙГ МОНГОЛ ХЭЛЭНД ТЭМДЭГЛЭХ ЗАРИМ АСУУДАЛД

Ха Иньхуа*

Монгол улс хөгжихийн хэрээр дэлхийн бусад улсын хэл сурах хүний тоо улам бүр нэмэгдэж байгаа бөгөөд Солонгос хэлийг ч бас багагүй сонирхон сурч байна. Солонгос улс монгол улстай дипломат харилцаа тогтоосноос хойш 20 жил өнгөрч буй бөгөөд энэхүү түүхтэй хамт МУИС-д албан ёсоор солонгос хэлний анги байгуулсаны 20 жил ч давхцаж буй. Энэ хугацаанд олон хүмүүс солонгос болон монголын тухай судалж ирсэн бөгөөд харилцан хоёр улсын хэлийг зааж сургахын төлөө олон сурах бичиг хэвлэгдэн билээ. Харин өнөөг хүртэл солонгос хэлийг монголоор, монгол хэлийг солонгосоор хэрхэн онолдуулан тэмдэглэх асуудал нэг мөр болоогүй байгаа нь үнэн юм.

Солонгос хэлийг монголоор тэмдэглэхэд хамгийн их алдаа гарч буй нь:

1. Солонгос хэлний эгшиг ‘ㄷ’, ‘ㅌ’, ‘ㄹ’, ‘ㅍ’, ‘ㅂ’, ‘ㅅ’, ‘ㅇ’.

2. Солонгос хэлний гийгүүлэгч ‘ㅏ’, ‘ㅑ’, ‘ㅓ’, ‘ㅕ’, дэвсгэр ‘ㅗ’, ‘ㅛ’ зэрэг эдгээр үсгийг монгол хэлд чухам ямар эгшиг, гийгүүлэгчтэй тохируулан тэмдэглэх асуудал маргаантай бөгөөд судлаачид ч нэг зүйлийг хэд хэдэн янзаар бичих асуудал хэвээр байгаа юм.

Хамгийн наад зах нь номын дэлгүүрт зарж буй сурах бичгээс харахад авиа дуудлага ижил ялган тэмдэглэхэд төвөгтэй зарим үсэг бол солонгос хэлний ‘ㅏ’, ‘ㅑ’ эгшиг, ‘ㅏ’, ‘ㅑ’ гийгүүлэгч, ‘ㅗ’ дэвсгэр үсгүүд байдаг.

Өнгөрсөн 3-р сард МУИС-ийн ГХСС-ийн Солонгос тэнхимээс зохион байгуулсан “Солонгос-Монгол дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал”-д тавьсан илтгэлүүдэд солонгос хэлийг монголоор тэмдэглэхэд гарсан зарим зөрөө мадагийг авч үзье.

Үүнийг уншигчид тус болохын үүднээс солонгос хэлийг латин үсгээр бас давхар тэмдэглэлээ. Харин 2000 онд засан сайжруулсан “Солонгос хэлийг латин үсгээр тэмдэглэх дүрэм” ба түүнээс өмнө хэрэглэж ирсэн тэмдэглэл өөр хоорондоо ялгаатай учир зассан дүрмээр тэмдэглэсэн нь аргагүй бөгөөд энэ сэдэвтэй төдийлэн хамаагүй учир дурдсангүй.¹

1. Дэвсгэр ‘ㅗ’ ба ‘ㅛ’-гийн ялгаа тодорхой бус байна.

* МУИС-ийн МХСС-ийн багш, докторант

¹ Солонгос үсгийг Ромын латин үсгээр тэмдэглэх дүрэм.(2000) // Солонгос соёл жуулчлалын яамны мэдээ, № -8. Сөүл.

Жишээ - 1

1	2	3
Квөн Сөнхүнъ	Кан Шин	Конгжү
권성훈	강신	공주
<i>Gwon Seonghun</i>	<i>Gang Sin</i>	<i>Gongju</i>

Дээрх 3 жишээний дунд 2(*Gang*), 3(*Gongju*) солонгос хэлний дэвсгэр ‘ㅇ’-р төгсөх үг бөгөөд, 1(*Gwon*) нь дэвсгэр ‘ㄴ’-р төгсөх үг боловч монголоор тэмдэглэсэн нь хэлний үзүүрийн ‘н’ үү, хэлний хойгуурхи ‘н’ үү гэдгийг ялгаж харуулж чадахгүй байна.

Мөн Солонгосын үсэг бүтээсэн хааны нэр болох ‘세종(Sejong)’-г тэмдэглэхэд ч бас зарим судлаач ‘Сэжунг’ гэж зарим нь ‘Сэжун’ гэж тэмдэглэж солонгосын дэвсгэр үсэг ‘ㅇ’-г монголоор өөр өөр тэмдэглэж байгааг харуулж байна. Ялангуяа ‘Бан Сү-ён’ гэж тэмдэглэсэн солонгос хүний нэрийг уншихад ‘방수영(*Bang Suyeong*)’, ‘방수연(*Bang Suyeon*)’, ‘반수연(*Ban Suyeon*)’, ‘반수영(*Ban Suyeong*)’ гэсэн 4 янзаар унших боломжтой болохоор зохиолч хэлэх гэж буй хүний нэрийг тодорхой дамжуулж чадахгүй болох асуудал тулгардаг.

2. Эгшиг үсэг тэмдэглэх асуудалд

2.1 ‘—’, ‘-|’-гийн тэмдэглэл

Монгол хүн солонгос хэл сурахад хамгийн хэцүү нь эгшиг ‘—’, ‘-|’-ийн дуудлага юм. Үүнийг монголоор тэмдэглэхэд ч бас ялгаагүй юм. Яагаад гэвэл солонгос ‘—’, ‘-|’ эгшигтэй адил авиа монгол хэлэнд байдаггүй учраас юм. Д. Сайнбилэгт солонгос хэлний эгшиг ‘—’-д хамгийн ойролцоо дуудах монгол эгшиг ‘ы’ гэсэн судалгаа гаргасан (2002:17)² боловч түүний судалгаанд ‘-|’-гийн талаас нь дурдсан юм үгүй байсан ба Гим Гисон(2002)³-ы монгол хэлийг солонгос үсгээр тэмдэглэх тухай судалгаанд монгол хэлний урт эгшиг ‘ы’-г солонгос хэлний ‘-|’-р тэмдэглэсэн боловч ‘—’ эгшгийн тухай тэмдэглээгүй учраас яг санаа нийлүүлсэнгүй гэж хэлж болно. Иймэрхүү байдлыг дараах жишээ тодорхой үзүүлж байна.

Жишээ - 2

1	2	3	4
Кей Сынхи	Хүнмин Жонг-ым	Хангыл	Ли Ы бэг
계승희	훈민정음	한글	이의백
<i>Gye Sunghui</i>	<i>Hunminjungeum</i>	<i>Hangeul</i>	<i>Yi Uibeg</i>

Жишээ 2-ын 1-3-т ‘—’ эгшгийг тэмдэглэсэн ба 4-т ‘-|’ эгшгийг тэмдэглэсэн боловч энэ хоёр эгшгийг хоёуланг монгол хэлний ‘ы’-р тэмдэглэснийг харж болно. Онцгойлон

² Д.Сайнбилэгт(2002) *Монгол -Солонгос хэлний дан эгшиг харьцуулах. // Солонгос соёл аялал жуулчлалын яамны мэдээ, № -8. Сөүл.*

³ Гим Гисон(2001) *Орчин цагийн Монгол хэлийг Солонгос Хангел үсгээр тэмдэглэх тухай. // Монгол судлал, №11. Сөүл.*

4(Ли) одоогийн БНСУ-ын зөв бичих дүрэм ба БНАСАУ-ын зөв бичих дүрэм⁴ хоёр өөр байгаагаас монголоор тэмдэглэхэд асуудал тулгарах боломжтой.

2.2 ‘ㄱ’, ‘ㄷ’-н тэмдэглэл

Жишээ - 3

1	2	3	4
О Юунь бү	Сон Хын рог	Но Мү Хён	Сэжун
오윤부	송홍록	노무현	세종
<i>O Yunbu</i>	<i>Song Heungrok</i>	<i>Roh⁵ Muhyeon</i>	<i>Sejong</i>

Дээрх жишээнүүдэд солонгос хэлний ‘ㄱ’ эгшгийг монгол хэлний ‘о’, ‘у’ эгшгээр тэмдэглэж байна. Солонгос хэлний эгшиг ‘ㄱ’, ‘ㄷ’ монгол хэлний ‘у’, ‘ү’-тэй дуудлага ижил гэсэн судалгаа(Д.Сайнбилэгт, 2002:17)-гаар харьцуулж үзвэл солонгосын ‘ㄱ’ эгшгийг монголын ‘у’ эгшгээр тэмдэглэх нь зүйтэй. Бас солонгосын ‘ㄷ’ эгшгийг тэмдэглэхэд ихэнх нь монголын ‘ү’-р тэмдэглэсэн байсан. Харин тийм биш тохиолдол ч байсан. Үүнд,

Жишээ - 4

1	2
Дун мүн юү хэ	Чон Ду Хуан
동문유해	전두환
<i>Dongmunyuhe</i>	<i>Jeon Duhwan</i>

зэрэг жишээг дурдаж болно.

2.3. ‘ㅏ’, ‘ㅑ’-ын тэмдэглэл

Дээр дурдсан ‘ㄱ’, ‘ㄷ’-тай адилхан ‘ㅏ’, ‘ㅑ’ эгшгүүдийг ч мөн өөр өөрөөр тэмдэглэснийг харж болно.

Жишээ - 5

1	2	3	4
Сө Са Гуан	Сөн Хйөнъ жа	Чөн Вөн жи	Чонг о нуголдай
서사광	성현자	정원지	청어노결대
<i>Seo Sagwang</i>	<i>Seong Hyenja</i>	<i>Jeong Wonji</i>	<i>Cheongo Nogeoldae</i>

Жишээ 5-ын 1-3-т солонгос эгшиг ‘ㅏ’-г монгол эгшиг ‘ө’-р тэмдэглэсэн. Харин 4 ‘о’-р тэмдэглэснээр өөр тэмдэглэлийг үзүүлж байна. Энэ ч бас Д. Сайнбилэгтийн судалгаанаас үзвэл солонгос хэлний ‘ㅏ’ эгшиг монголын ‘о’ эгшигтэй төстэй гэж үзсэн байна(2002:15). Солонгос хэлний эгшиг ‘ㅑ’ тэмдэглэл ч мөн дээрх жишээнд тэмдэглэсэн 2(Сөн Хйөнъ жа)-тэй ижил тэмдэглэл байсан. Жишээлбэл,

Жишээ - 6

1	2	3
---	---	---

⁴ БНАСАУ(1987) *Жусонь хэлний зөв хэрэглэх дүрэм*. 1987 ОНД ЗАСААД ТОГТООСОН. Пёняан.

БНСУ-ын зөв бичих дүрмийн 11-р хэсэгт : Ханзын ‘랴, 려, 례, 료, 류, 리’-ны дуудлагатай үсэг үгийн эхэнд орвол толгой үсэг унших зарчмын дагуу ‘야, 여, 요, 유, 이’-гаар тэмдэглэнэ. Гэхдээ эгшиг болон ‘ㄴ’ дэвсгэрийн дараа ‘랴, 료’ байвал ‘열, 을’ гэж тэмдэглэнэ. БНАСАУ-ын зөв бичих дүрмийн 25-р хэсэгт: Ханз үгийн дуудлага тэр чигээрээ бичнэ.

⁵ Солонгосын “Ну” өвөгийн алтан ургийн чуулганы 2008 оны их хуралд латинаар “Roh” гэж тэмдэглэхийг тогтоосон.

Пак Бйөн-үк	И Мён Пак	Ким Хйёнъ ра
박병욱	이명박	김현라
<i>Bak Byeonguk</i>	<i>Yi Myeongbak</i>	<i>Gim Hyeonra</i>

Жишээ 6-гын 1 ба 3 дээрх жишээний 2-тэй адил 'йө'-р тэмдэглэсэн. Харин 2 дах жишээнд 'ё'-р тэмдэглэсэн байна. Гим Гисон(2001) монгол хэлийг солонгос хэлээр тэмдэглэх асуудлын туай ярихдаа монгол хэлний 'ё'-г солонгос хэлний 'ㅉ' –той дүйцүүлэн тэмдэглэжээ.

3. Гийгүүлэгч үсгийг тэмдэглэх асуудалд

Солонгос хэлийг монголоор тэмдэглэхэд дэвсгэр эгшгээс гадна гийгүүлэгчийг тэмдэглэх тухай асуудал ч гардаг. Тэдгээрийн ихэнх нь 'ж, ч', 'б, п', 'г, к', 'д, т'-г хольж хэрэглэх явдал юм. Жишээлбэл,

<Жишээ 7>

Гим Чин ха	Ким Ү Жүн
김진하	김우중
<i>Gim Jinha</i>	<i>Gim Ujung</i>

Энэ тохиолдолд солонгос хэлийг латин хэлээр тэмдэглэхэд 'Kim' гэж бичиж байсан болохоор 'г, к' зэрэгцүүлж хэрэглэх боломж байгаа гэж үзэх боловч монгол хэлний дуудлагын хувьд 'ㄱ'-р тэмдэглэх нь 'к' –ээс 'г' нь уг авиатай ижил дуудаж байгааг мэдэж болно.

<Жишээ 8>

1	2	3
Чосөн	Чэгүгтайжан	Жон Жин Чол
조선	제국대장	정진철
<i>Joseon</i>	<i>Jegugdaejang</i>	<i>Jung Jincheol</i>

Энэ тохиолдолд 1,2 жишээ '조선(choseon)', '제국태장(Chegugtaejang)' гэж дуудах болохоор өөр тэмдэглэл болсныг мэдэх болно. 3-ын 'ж' зөв тэмдэглэсэн боловч солонгос хэлний дэвсгэр 'ㄷ' ба 'ㅇ'-г ялгах хэрэгтэй ч гэсэн бүгд 'н'-г хэрэглээд дуудлагын хувьд төгс бус тэмдэглэлийг харуулж байна.

<Жишээ 9>

Бэ Юн Жүн	И Мён Пак	Пак Бйөн-үк
배용준	이명박	박병욱
<i>Bae Yongjun</i>	<i>Yi Myeongbag</i>	<i>Bag Byeonguk</i>

Солонгос хэлний 'ㅂ' гийгүүлэгч монгол хэлний 'б' гийгүүлэгчтэй тохирох авиа мөн. Тиймээс 'п'-р тэмдэглэх нь буруу. Энэ нь солонгос хэлний 'ㅍ'-г тэмдэглэх тохиолдолоос ялган зааглахад хэрэгтэй зүйл юм.

Дээрээс дурдсан цөөн жишээгээр энэ асуудлыг бүхэлд нь нарийн тайлбарлаж чадахгүй ч гэсэн солонгос хэлийг монгол хэлээр тэмдэглэх тухай асуудлын нэгээхэн

хэсэг болж тайлбарласан гэж бодож байна. Цаашид солонгос монгол хоёр улс илүү ойр дотно харилцаатай болж олон салбарт идэвхитэй ажиллахад тус хоёр улсын хэлийг харилцан зөв тэмдэглэх нь харилцагч улсаа хүндэтгэж байгаа зүйл гэж бодож байна. Тиймээс эн түрүүнд солонгос хэлийг монгол хэлээр тэмдэглэх асуудлын тухай товчхон авч үзлээ.

Энэ өчүүхэн зүйл жижиг алхам болж солонгос-монгол хэлийг зөв бичиж тэмдэглэх жишиг тогтоож хоёр улс хоорондын итгэл найдвар нэмэгдэх ажилд тус болоосой хэмээн хүсэж байна.

Иймэрхүү асуудлыг шийдэхийн тулд солонгос хэлний дэвсгэр үсэг ‘ㄴ’-г монгол хэлний ‘нб’-аар, ‘ㅇ’-г монгол хэлний ‘н’ гийгүүлэгчээр, ‘ㄷ, ㅌ’ эгшгийг ‘у, ү’ эгшгээр, үгийн эхэнд ордог ‘ㄱ’-г ‘г’-гээр, гийгүүлэгч ‘ㅍ’-г ‘б’-гээр, ‘ㅈ’-г ‘ж’-гээр тэмдэглэх санаа дэвшүүлж байна. Харин ‘ㅡ, ㅣ’-ын талаас нь илүү гүнзгий судлаах хэрэгтэй тул тодорхой дүгнээгүй болно. Дараагийн судалгаандаа эгшиг гийгүүлэгч тус бүрийг дахин нарийн нягталж эдгээрийг тус хоёр хэлэнд харилцан хэрхэн тэмдэглэх тухайд тодорхой авч үзэх болно.

НОМЗҮЙ

- МУИС ГХСС Солонгос хэлний тэнхим(2011) *Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан Эрдэм шинжилгээний хурал*. Улаанбаатар.,
- Гим Гисон(2001) *Орчин цагийн Монгол хэлийг Солонгос Хангөл үсгээр тэмдэглэх тухай*. // Монгол судлал, №11. Сөүл.,
- Д.Сайнбилэгт(2002) *Монгол -Солонгос хэлний дан эгшиг харьцуулах*. // Олон улсын Солонгос хэлний боловсролын судлал. Сөүл.,
- Гим Согён(2002) *Монгол хэлийг Солонгос үсгээр тэмдэглэхийн утга учир*. Монгол судлал, №12. Сөүл.
- Ш.Чоймаа (2011)*Монгол бичиг сурах ач холбогдол I*. Улаанбаатар.,
- Д.Цэрэнпил, Р.Куллманн(2008)*Монгол хэлний хэлзүй*. Улаанбаатар.,
- (2000) *Солонгос хэлийг Ромын латин үсгээр тэмдэглэх дүрэм*. // Солонгос Соёл Аялал Жуулчлалын Яамны мэдээлэл № 2000-8. Сөүл.
- Улсын Солонгос хэл судлах төв(1989)*Солонгос хэлний зөв бичих дүрэм*. 1988 онд засаад тогтоосон. Сөүл.
- БНАСАУ(1987) *Жусонь хэлний зөв хэрэглэх дүрэм*. 1987 онд засаад тогтоосон. Пёнян.

SUMMARY

There are over 20 years of bilateral diplomatic relations between Mongolia and the Republic of Korea. This period has witnessed a great increase of people learning Korean or Mongolian, as well as the release of numerous textbooks and dictionaries. However, what is requiring an urgent attention is that there is an absence of unified principle in transliteration between these two languages.

The comparative study of Korean-Mongolian letter writing is important for respective partnership and relationship of these countries in many fields. The following is a short review for shortly marking Korean letters in the Mongolian language (cyrillic).